



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 57

Мандалговь

Зээлийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.4, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.3.2, 3.5.8, Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 72 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 11.2, 11.3 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. “Сум хөгжүүлэх сан”-аас “Эсгий үйлдвэрлэл” зориулалтаар зээл авсан “Тэнүүн.govийн баялаг” ХХК-ны үйлдвэрийн байр, түүхий эд, бүтээгдэхүүн нь 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн байгалийн гамшигт нэрвэгдсэн байдлыг харгалзан үзэж үндсэн зээлийн төлөлтийг 8 сараар сунгахыг Засаг дарга (С.Бат-Оргил), ня-бо (Н.Саранзаяа) нарт зөвшөөрсүгэй.

2. Зээлийн зориулалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, гэрээний өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг Засаг дарга (С.Бат-Оргил), Сум хөгжүүлэх сангийн нарийн бичиг (Ш.Бямба) нарт хариуцуулсугай.

3. Үйлдвэрлэлийн байраа сэргээн тохижуулж, зээлийг сунгасан хугацаанд нь нэмэлт гэрээний дагуу төлж барагдуулахыг “Тэнүүн.govийн баялаг” ХХК-ний захирал (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА 
T. БАТЖАРГАЛ